

2025 ОНД ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХИЙГДСЭН АЖЛУУДЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2026.01.02

Хоолт

Тус суманд орон нутгийн хөгжлийн санд 2025 онд 779128.3 мянган төгрөгийн 17 төсөл арга хэмжээ, малын тоо толгойн албан татвараар 111000,0 мянган төгрөгөөр 7 төсөл арга хэмжээ нийт 890128,3 мянган төгрөгөөр 24 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдаж орон нутгийн хөгжлийн санд 481661,3 мянган төгрөгийн санхүүжилт, оны эхний үлдэгдэл 376967,0 мянган төгрөг, малын тоо толгойн албан татварын орлогоос 31500.0 мянган төгрөгийн эх үүсвэртэй батлагдсан байна.

2025 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 24 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулснаас 20 арга хэмжээг 100 хувь бүрэн хэрэгжүүлж, 4 төсөл арга хэмжээг төсөв хүрэлцэхгүйн улмаас он дамжуулан хэрэгжүүлэхээр болсон байна. Хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг авч үзвэл Үүнд:

1. “Дук машин”-ыг харьцуулалтын аргаар тендер зарлаж Оттомир ХХК шалгарч 65,800,000 мянган төгрөгөөр нийлүүлсэн.





2. Иргэдэд үйлчлэх төв, хүндэтгэлийн өргөөний засвар тохижилтийн ажлыг харьцуулалтын аргаар тендер зарлаж 38,000,000 төгрөгөөр Дэлгэрэх минериал ХХК гүйцэтгэсэн.







3. Соёлын төвийн техник хэрэгсэл 20,000,000 төгрөгөөр шууд гэрээ байгуулах аргаар Би саунд продакшн гүйцэтгэсэн.






4. Цэцэрлэгийн дотоод тохижилтыг харьцуулалтын аргаар 34,510,000 төгрөгөөр Дэлгэрэх минериал ХХК хийж гүйцэтгэж байна.






5. Багийн төвүүдийн тохижилт засварын ажлыг харьцуулалтын аргаар тендер 58,080,000 төгрөгөөр Сүүхүнгий ХХК шалгарч хийж гүйцэтгэж байна.




6. Сургуулийн дотоод орчны тохижилтыг харьцуулалтын аргаар тендер зарлаж 42,000,000 төгрөгөөр Дентист орхон ххк шалгарч хийж гүйцэтгэсэн.






7. Цаг уурын газардуулга /аянга зайлуулагч/ ажлыг шууда худалдан авалтын аргаар 19,200,000 төгрөгөө Төгрөг угалз ХХК хийж гүйцэтгэсэн.



8. Гэрэлтүүлгийн засврын ажлын шууд гэрээ байгуулах аргаар 870,000 төгрөгөөр Б.Батзаяа М.Алтангэрэл хийж гүйцэтгэсэн.





9. Хуучин эмнэлгийн засварын ажлыг шууд худалдан авалтын аргаар 18,500,000 төгрөгөөр Залба хайрханы хишиг ХХК хийж гүйцэтгэсэн.



10. Хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх 5,000,000 төгрөгөөр аймгийн Цаг уур орчны шинжилгээний газар гүйцэтгэсэн.

11. Ундны ус болон бэлчээрийн уст цэгүүдийн засварын ажлыг харьцуулалтын аргаар 29,700,000 төгрөгөөр Арвай вэлл дриллинг ХХК гүйцэтгэсэн




12. Засмал зам үерийн ус зайлуулах байгууламжийн зураг төсвийн ажлыг харьцуулалтын аргаар 55,977,600 төгрөгөөр Зууны хөгжлийн зам ХХК шалгарч хийж гүйцэтгэсэн байна.


13. Дулааны шугамын өргөтгөлийн зураг төсвийг шууд худалдан авалтын аргаар Дөрвөн гүн ХХК 19,500,000 төгрөгөөр гүйцэтгэсэн байна.

14. Услалтын систем 19,000,000 төгрөгөөр хийгдсэн. 2022 оны 5 сард Хөдөө аж ахуйг дэмжих сангаас зээлийн гэрээ байгуулан авч жил бүр орон нутгийн хөгжлийн сангаас төлөлт хийж байна.

15. Малын тоо толгойн албан татвараар хийгдэж буй Малын үүлдэр омог сайжруулах ажлыг 8,000,000 төгрөгөөр 2 дугаар иргэн Д.Майнцэцэгтэй шууд гэрээ байгуулан 20 хээлтэгч, 1 хээлтүүлэгчийг хүлээлгэн өгсөн.



16. Малын тоо толгойн албан татвараар хийгдэх гамшгаас хамгаалах зардлаас 7,741,100 төгрөгийг малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалт, малчдаас ирсэн сэжигтэй дуудлага, байгалийн гамшигт үзэгдэлт өртсөн малын устгал булах ажлын замын зардал болон ариутгал халдвар хамгаалалын зардалд зарцуулсан.





17. Малын тоо толгойн албан татвараар хийгдэх гүн өрмийн худаг засварлахад 19,500,000 төгрөгөөр шууд худалдан авагдтын аргаар Залба хайрханы хишиг ХХК шалгарсан сайн төгрөгийн 4 дүгээр баг, Баянгийн 5 дугаар багт 8 худагт 8 насос, 8 моторыг нийлүүлсэн.

18. Малын тоо толгойн албан татвараар хийгдэх өвс тэжээлийн нөөц бүрдүүлэхэд 18,000,000 төгрөгийн 9,000,000 төгрөг хивэг Ц.Азжаргал, шар солон 9,000,000 төгрөгөөр Буян орших буудай ХХК тус тус нийлүүлсэн байна.



20. Малын тоо толгойн албан татвараас санхүүжигдэх мал эрүүлжүүлэхэд 2100 ширхэг ивомекийг 1 ширхэгийн 5000 төгрөгөөр нийт 10,500,000 төгрөгөөр Ветпро ХХК хамгийн бага үнийн саналаар шалгаран нийлүүлсэн байна. Мөн 5,600,000 төгрөгөөр малын вакцинжуулалтын зардалд зарцуулсан. Вакцинжуулалтын замын зардлыг Г.Лхамхүү нийлүүлсэн.



Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын тендерийн худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулж, харьцуулалтын аргаар 7, шууд худалдан авалтын аргаар 13 тендерийг зарлаж гүйцэтгэсэн байна. Худалдан авах ажиллагааг 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулж, тендерийн үр дүнг цахим сайтад нийтэлсэн.

ТАЙЛАН БИЧСЭН:

НЯГТЛАН БОДОГЧ

ХЯНАСАН

ЗАСАГ ДАРГА

Л.ОРГИЛМӨНХ

Д.БАТСАЙХАН

